

МУИС, ХШУИС, ОЙН  
ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН  
ТЭНХИМИЙН БАГШ ДЭД  
ПРОФЕССОР Н.ОЮУНЧИМЭГТ

Санал хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Сургууль, Хэрэглээний Шинжлэх Ухаан Инженерчлэлийн Сургуулийн Хүрээлэн буй Орчин, Ойн Инженерчлэлийн тэнхимийн 2022 -2023 оны хичээлийн жилд “Байгаль хамгаалал ба тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент” ахисан түвшиний хичээлийн тодорхойлолттой танилцаж, дараах саналыг хүргүүлж байна.

1. Хүрээлэн буй Орчин, Ойн Инженерчлэлийн тэнхим нь ахисан түвшиний “Хүрээлэн буй орчин судлал”, Байгаль орчныг хамгаалах технологи” хөтөлбөрөөр мэргэжилтэн бэлтгэдэг. Тус хичээлийн агуулга хүний хүрээлэн буй орчин, түүний бүрэлдэхүүн хэсгүүд болон байгалийн нөөцийн ашиглалтын тухай ухагдахууныг хамарч, байгаль хамгаалал, судалгаа шинжилгээний өндөр ач холбогдол бүхий хамгаалалттай газар нутгийн менежментийг боловсруулах, хэрэгжүүлэхэд ашигладаг мэргэжлийн программ хангамж дээр ажиллах арга зүйг сурж, дадлагажих боломжийг суралцагчид өгч байгаа нь шинэлэг, өндөр ач холбогдолтой юм. Ингэснээр төгсөгч эзэмшсэн байх ёстой ур чадварыг энэ хичээлээр бүр олгох боломжтой.
2. Хичээлийг байгаль хамгаалал, тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент гэж 2 бүлэг болгон хуваарьлавал илүү тохиромжтой болов уу. Улирлын эхний хагаст байгаль хамгааллын асуудлыг хөндөж, хоёрдугаар хагаст Тусгай хамгаалалттай газар нутаг, түүний үйл ажиллагаанд чиглэсэн сэдэвүүд байх нь хичээлийн зорилгод нийцнэ. Хичээлийн агуулга, дэс дарааллын хувьд тодорхой 2 санал байна.
  - а. 8 болон 7-р хичээлийн дэс дарааллыг сольвол цаашид орох сэдэвийн тэс дараалал илүү тохиромжтой байх юм.
  - б. Хичээлийн агуулгыг тусгай хамгаалалттай газар нутгийн менежменттэй уялдуулахдаа дараах байдлаар өөрчилж болох юм.
    - і. Усны болог газрын нөөцийн ашиглалт, хамгаалал – Хамгаалалттай газар нутгийн усны нөөц, газар ашиглалтын менежмент гэх мэт
3. “Байгаль хамгаалал ба тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент” ахисан түвшиний хичээл нь МУИС-ийн Сургалтын журамд бүрэн нийцэж байна.

Хүрээлэн буй орчин судлал, Ойн инженерчлэлийн тэнхимийн  
ахлах багш Б.Ариунсанаа

*Ариун*

2022.09.14